

ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ГЭРЭЭ

2019 оны 08 сарын 05-ны өдөр

Дугаар 19/167157/61

Улаанбаатар хот

Энэхүү гэрээ (цаашид "Гэрээ" гэх)-г Монгол Улсын Иргэний хуулийн үүргийн нийтлэг үндэслэл, 343-358 дугаар зүйлийг тус тус баримтлан :

Нэг талаас "Монголын төмөр зам" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал **Б.Цэнгэл** (цаашид "Захиалагч" гэх);

Нөгөө талаас "Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн" ТӨҮГ-ын Төсөл хөтөлбөрийн ахлах инженер **Ш.Энхбаатар** (цаашид "Гүйцэтгэгч" гэх) нар (цаашид хамтад нь "Талууд" гэх) ажил гүйцэтгэхтэй холбоотой харилцааг зохицуулах үүднээс дор дурдсан нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

1. Нийтлэг үндэслэл

- 1.1. Гүйцэтгэгч нь Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын цахилгаан хангамжийн ажлын зураг төслийг өгөгдсөн техникийн нөхцөл, зургийн даалгаврын дагуу боловсруулан захиалагчийн өмчлөл буюу эзэмшилд шилжүүлэх, захиалагч нь гүйцэтгэгчид ажлын хөлсийг төлөхтэй холбоотой үүсэх харилцаанд талуудын эрх үүрэг хариуцлагыг тодорхойлж зохицуулна.
- 1.2. Энэхүү гэрээ нь түүний хавсралтуудаас бүрдэнэ. Түүний хавсралтад оруулсан нэмэлт, өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг байх бөгөөд гэрээний хамт хүчин төгөлдөр болно.
- 1.3. Гүйцэтгэгч нь зураг төслийг техникийн нөхцөл, зураг төсөл боловсруулах даалгавар, горимын тооцоо, Геологи хайгуулын судалгаа, Геодезийн хэмжилтийг үндэслэн боловсруулна. Захиалагч нь дээрх материалуудыг гүйцэтгэгчид хүлээлгэн өгөх ба тус материалууд нь баталгаажсан байна.
- 1.4. Талууд ажлын зураг төслийг боловсруулах хугацаа болон хөлсийг тус гэрээнд тодорхой заасан байна.

2. Баталгаа

- 2.1. Гүйцэтгэгч нь дараах баталгааг гаргана.

- 2.1.1. Гэрээний дагуу ажил гүйцэтгэх, гэрээнээс үүсэх эрх, үүргийг хэрэгжүүлэх эрхтэй, энэхүү гэрээг байгуулах, бүртгүүлэх, хэрэгжүүлэхэд шаардлагатай Тусгай зөвшөөрөл, эрхийг эрх бүхий байгууллагаас авсан, тэдгээр нь гэрээний үүргийг зохих ёсоор бүрэн гүйцэтгэж дуусах хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр, гэрээнд заагдсан ажлыг гүйцэтгэх мэргэжлийн боловсон хүчин, санхүүгийн бүрэн чадамжтай гэдгийг;

- 2.1.2. Гүйцэтгэгч нь ажлыг Хууль тогтоомж болон энэ гэрээнд заасан шаардлага, Эрчим хүчний стандарт, норм, нормативт нийцүүлэн, эрхийн болон биет байдлын доголдолгүй, холбогдох бичиг баримтын хамт үнэн зөв, иж бүрдэлтэй, бүрэн гүйцэд хүлээлгэж өгнө гэдгийг;
- 2.1.3. Талууд энэхүү гэрээг байгуулах, хэрэгжүүлэхтэй холбогдуулан олж мэдсэн нөгөө талын үйл ажиллагаатай холбоотой нууц мэдээллийг тухайн талын зөвшөөрөлгүйгээр хууль болон энэ гэрээнд зааснаас бусад тохиолдолд бусдад задруулахгүй, энэхүү гэрээнээс үүссэн харилцаанаас өөр бусад зорилгоор ашиглахгүй байхыг;

3. Гүйцэтгэх ажил, ажлын гүйцэтгэл

- 3.1. Энэхүү гэрээгээр Тавантолгой Зүүнбаян чиглэлийн төмөр замын цахилгаан хангамжын ажлын зураг төслийг өгөгдсөн техникийн нөхцөл болон зураг төсөл боловсруулах даалгаварыг үндэслэн ажлын зураг төслийг боловсруулна.
- 3.2. Гүйцэтгэгч зураг төсөлд эрх бүхий байгууллагаар магадлал хийлгэх, дүгнэлт гаргуулан баталгаажуулж Захиалагчид хүлээлгэн өгнө.

4. Ажил гүйцэтгэх хугацаа

- 4.1. Гүйцэтгэгч нь ажлыг **70** хоногийн хугацаанд багтаан гүйцэтгэх буюу 2019 оны 08 дугаар сарын 05-ны өдрөөс эхлүүлэн тогтоосон хугацаанд гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж хүлээлгэн өгнө.
- 4.2. Гэрээ байгуулсан эсэхээс үл хамааран Гүйцэтгэгч ажлаа эхэлсэн байж болно.
- 4.3. Захиалагчийн шаардсан тухай бүрт Гүйцэтгэгч нь хийгдэж буй ажлын талаар зохих мэдээлэл, гэрээний хэрэгжилт, тайланг хүргүүлэх ба эдгээр нь ажлын хөлс, төлбөр төлөх үндэслэл болно.
- 4.4. Ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй, эсхүл хугацаа хожимдуулж гүйцэтгэсэн нь Гүйцэтгэгчид Захиалагчийн зүгээс хууль болон энэ гэрээнд заасан алданги болон торгууль ногдуулах үндэслэл болно.

5. Ажлын хөлс, төлбөр тооцоо

- 5.1 Гэрээгээр гүйцэтгэх ажлын нийт хөлс **224 126 100** /хоёр зуун хорин дөрвөн сая нэг зуун хорин зургаан мянга нэг зуу/ төгрөг. Энэ үнийн дүнд зураг төсөл боловсруулах болон зураг төсөлд магадлал хийлгэх үнэ, НӨАТ-ыг оруулан тооцсон дүн болно.
- 5.2 Захиалагч гэрээт ажлын урьдчилгаа төлбөр болох гэрээний үнийн дүнгийн 50% буюу **112 063 050** / нэг зуун арван хоёр сая жаран гурван мянга тавин / төгрөгийг гэрээ батлагдсан өдрөөс хойш ажлын 3 хоногт багтаан шилжүүлнэ. Гэрээний үлдэгдэл **112 063 050** / нэг зуун арван хоёр сая жаран гурван мянга тавин / төгрөгийг гэрээт ажлыг гүйцэтгэж дуусган талууд ажил хүлээлцсэн акт

үйлдсэнээс хойш ажлын 5 хоногийн дотор “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-ын Худалдаа хөгжлийн банкны **406001061** дансанд тус тус шилжүүлж төлбөрийг барагдуулна.

- 5.3 Ажил гүйцэтгэхэд шаардагдах техник, тоног төхөөрөмж болон бусад зардлыг гүйцэтгэгч тал өөрөө хариуцна.

6. Ажлын доголдлыг арилгах, гомдлын шаардлага гаргах

- 6.1. Талууд ажлыг чанаргүй гүйцэтгэсэн, эсхүл Захиалагч, төрийн эрх бүхий хяналтын байгууллагын бичгээр өгсөн чиглэл, удирдамжийг зөрчиж гүйцэтгэсэн нь ажлын гүйцэтгэлийг хянах явцад болон энэ гэрээний гомдлын шаардлага гаргах хугацаанд илэрсэн бол уг зөрчлийг үнэ төлбөргүй дахин засварлаж захиалагчид хүлээлгэн өгнө.
- 6.2. Талууд ажлын үр дүнгийн доголдлын талаар санаатай нуун дарагдуулсан нь хожим илэрвэл тэрээр хариуцлагаас бүрэн буюу хэсэгчлэн чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.
- 6.3. Талууд гэрээний нөхцөлийг зөрчсөн буюу гүйцэтгэсэн ажилд ямар нэг доголдол байвал ажил хүлээн авснаас хойш хуульд заасан хугацаанд гомдлын шаардлага гаргах эрхтэй.

7. Мэдээлэл солилцох, мэдээллээр хангах

- 7.1. Талуудын албан ёсны хаяг:

- 7.1.1. Захиалагч: "Монголын төмөр зам" төрийн өмчит хувьцаат компани

Улсын бүртгэлийн дугаар: 9012001025
Регистрийн дугаар: 5214203

Хаяг: Юнион бюлдинг, А блок, 7 давхар, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,
13 хороолол, Нарны зам-62, Улаанбаатар /14230/

Утас: 7000-6622, 7010-6655
Имэйл: info@mtz.mn

- 7.1.2. Гүйцэтгэгч: “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ

Улсын бүртгэлийн дугаар: 9013001028
Регистрийн дугаар: 2541203

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар:ЗТ-017/17

Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 19 дүгээр хороо,
Чингүнжавын гудамж-, "ЭХЭЗХ" ТӨҮГ

Утас: 76115678, 88043446, 99075097

И-мэйл: info@meei.energy.gov.mn

- 7.2. Гэрээний талууд үйл ажиллагаа эрхлэн явуулахад шаардлагатай мэдээллийг зөвхөн албан бичгээр харилцан солилцож байна.
- 7.3. Мэдээллийг бичгээр харилцахдаа факс, и-мэйл зэрэг цахим хэлбэрийг ашиглана.
- 7.4. Хойшлуулшгүй тохиолдолд Талууд мэдээллээ амаар болон утсаар солилцож болох боловч ийнхүү солилцсон мэдээллээ баталгаажуулж 24 цагийн дотор нөгөө талд бичгээр хүргүүлнэ.
- 7.5. Захиалагч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай мэдээ баримт, судалгаа, зааварчилгааг Гүйцэтгэгчийн хүсэлтийн дагуу тухай бүр гаргаж өгнө.

8. Ажил хүлээлцэх

- 8.1. Талууд ажлын гүйцэтгэлийг хүлээлцэхдээ тал тус бүрээс 2-оос доошгүй ажилтан оролцуулсан ажил хүлээлцэх комисс байгуулж ажлыг хүлээлцэнэ.
- 8.2. Талууд гэрээний дагуу ажлын гүйцэтгэлийг хүлээлцсэнээс хойш 3 /гурав/ хоногийн дотор ажлын бичиг баримтыг акт үйлдэн хүлээлцэнэ.
- 8.3. Зураг төслийг гэрээнд заасан хугацаанд чанартай боловсруулан улсын экспертизээр хянуулан баталгаажуулсан зураг төслийг, төсвийн хамт захиалагчид хүлээлгэн өгнө. Зураг төслийг эх хувь, хуулбар 2%-тай, төсвийг эх хувь, хуулбар 1%-ийн хамт тус тус хүлээлгэн өгнө.
- 8.4. Ажил хүлээлцсэнээр Ажлын үр дүн нь Захиалагчийн өмчлөлд шилжинэ.

9. Захиалагчийн эрх, үүрэг

- 9.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэхийг Гүйцэтгэгчээс шаардах;
- 9.2. Ажлын явцын тайланг Гүйцэтгэгчээс авах;
- 9.3. Гүйцэтгэгч талын үйл ажиллагаанд илэрсэн алдаа, ажлын тайлан, дүгнэлтийн хувьд гарсан бүх алдаа, зөрчлийг үнэ төлбөргүй дахин хийлгэх, шинээр хийлгэх талаар шаардлага тавих;
- 9.4. Шаардлагатай тохиолдолд ажлын гүйцэтгэлд нарийн мэргэжлийн байгууллагаар хөндлөнгийн хяналт, шалгалт хийлгэх;
- 9.5. Захиалагч нь энэхүү гэрээнд заасны дагуу гэрээний төлбөрийг Гүйцэтгэгчид хугацаанд нь төлөх;
- 9.6. Гэрээт ажлыг хугацаанд нь гүйцэтгэхэд өөрсдийн зүгээс шаардлагатай тусалцааг Гүйцэтгэгч талд үзүүлэх;
- 9.7. Захиалагчийн зүгээс ажил хийж гүйцэтгэхтэй холбогдсон шаардлагатай

мэдээ, мэдээлэл /горимын тооцоо, инженер геологийн дүгнэлт, инженер геодезийн тайлан, ус зүйн тооцоо, түгээмэл тархацтай ашигт малтмалын судалгааны тайлан, дэд өртөөний байршилууд болон төлөвлөлтийн зургууд/-аар хангах;

- 9.8. Захиалагчийн зүгээс шаардлагатай материалуудыг хугацаанд ирүүлээгүй хоног тутам нь гэрээнд заасан хоног дээр нэмэгдэнэ. Энэ нь албан бичиг болон баримтаар баталгаажсан байна.
- 9.9. Энэхүү гэрээнд заасан бусад эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

10. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

- 10.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэхийг Захиалагчаас шаардах;
- 10.2. Гэрээнд заасны дагуу гэрээний төлбөрийг хүлээн авах;
- 10.3. Захиалагч талаас гаргаж өгөх ажлын хүрээндэх мэдээ материалыг цаг хугацаанд нь шаардан авах;
- 10.4. Зураг төслийг шалгах, хэрэгжүүлэх явцад алдаа дутагдал илэрвэл түүнийг дахин үнэ төлбөргүй шуурхай шийдвэрлэж өгнө.
- 10.5. Гэрээт ажилтай холбоотой захиалагчаас ирүүлсэн материалыг ажил дууссаны дараа захиалагчид хүлээлгэн өгнө.
- 10.6. Захиалагч нь гэрээт ажлыг хугацаанд нь хүлээн авах үүргээ биелүүлээгүй бол уг ажлыг авсанд тооцон ажлын хөлсийг төлөхийг захиалагчаас шаардах эрхтэй.
- 10.7. Захиалагч талын зөвшөөрөлгүйгээр гэрээний эрх, үүрэг, хариуцлагыг бусдад шилжүүлэхгүй байх үүрэгтэй.
- 10.8. Ажлын үр дүн, тайлан дүгнэлтэд тусгагдсан норматив болон тооцооны үзүүлэлтүүдийн үнэн зөвийг бүрэн хариуцах;
- 10.9. Энэхүү гэрээнд заасан бусад эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

11. Нууцлал

- 11.1. Гэрээ нь Талуудын нууцад хамаарах бөгөөд хууль болон гэрээнд зааснаас бусад тохиолдолд нөгөө Талын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр гэрээний талаарх аливаа мэдээллийг бусдад задруулахыг хориглоно.
- 11.2. Хуульд заасны дагуу байгууллагын нууцтай танилцах эрх бүхий төрийн байгууллага, түүний албан хаагч энэ зүйлд заасан мэдээлэлтэй танилцахаар хүсэлт гаргасан, эсхүл шаардсан тохиолдолд талууд уг мэдээллийг хуульд заасан журмын дагуу танилцуулах бөгөөд энэ талаар нөгөө талдаа заавал урьдчилан мэдэгдэнэ.
- 11.3. Талуудын аль нэг нь энэ зүйлд заасан үүргээ зөрчсөний улмаас нөгөө талын бизнесийн нэр хүндэд ноцтой хохирол учирсан, материаллаг хохирол учруулсан бол буруутай тал нь түүнийг бүрэн хариуцна.

12. Гэрээг байгуулсанд тооцох

- 12.1. Гэрээнд талуудын төлөөлөх эрхтэй этгээд гарын үсэг зурж баталгаажуулснаар гэрээ хүчин төгөлдөр болно.
- 12.2. Гэрээг Монгол хэлээр хоёр хувь үйлдэх ба Гүйцэтгэгч, Захиалагч тус бүр нэг хувийг хадгалах бөгөөд эдгээр хууль зүйн адил хүчинтэй байна.

13. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах

- 13.1. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг Талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
- 13.2. Талууд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд нөгөө Талдаа саналаа бичгээр хүргүүлэх бөгөөд тухайн саналд нэмэлт, өөрчлөлтийн үндэслэл, түүний төслийг тусгана.
- 13.3. Саналыг хүлээн авсан тал ажлын 5 хоногийн дотор хариу ирүүлэх үүрэгтэй бөгөөд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, цуцлах асуудлыг шийдвэрлэнэ.
- 13.4. Гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг байна.

14. Гэрээний зөрчлийг арилгах, гэрээ цуцлах

- 14.1. Талууд гэрээний үүргийн зөрчлийг арилгах тухай нөгөө талдаа бичгээр мэдэгдэл хүргүүлэх бөгөөд мэдэгдлийг хүлээн авсан тал гэрээний зөрчлийг 7 хоногийн дотор арилгаж хариу мэдэгдэх үүрэг хүлээнэ.
- 14.2. Хэрэв зөрчил гаргагч Тал зөрчлийг 10 хоногийн дотор арилгах боломжгүй бол энэ тухай нөгөө Талдаа мэдэгдэх бөгөөд зөрчил арилгах хугацааг Талууд харилцан тохиролцож тогтооно.
- 14.3. Талууд гэрээг цуцлах саналтай байгаа бол уг саналаа нөгөө Талд бичгээр хүргүүлж, харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
- 14.4. Захиалагч нь дараах тохиолдолд гэрээг дангаар цуцлах эрхтэй. Үүнд:
 - 14.4.1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэхдээ чанарын ноцтой доголдол гаргасан бөгөөд захиалагч ажлыг цаашид үргэлжлүүлэн гүйцэтгэх боломжгүй гэж үзсэн;
 - 14.4.2. Гүйцэтгэгч нь ажлын доголдлыг боломжит хугацаанд арилгаагүй, эсхүл ийнхүү арилгахаас зайлсхийсэн;
 - 14.4.3. Гүйцэтгэгчийн баталгаа нь хуурамч болох нь илэрсэн;
 - 14.4.4. Гэрээгээр хүлээсэн үүргээ 2 буюу түүнээс дээш удаа ноцтой зөрчсөн.
- 14.5. Гүйцэтгэгч дараах тохиолдолд гэрээг дангаар цуцлах эрхтэй. Үүнд:
 - 14.5.1. Захиалагч төлбөрөө шилжүүлэх хугацааг 10 буюу түүнээс дээш хоногоор хэтрүүлсэн, цаашид боломжит хугацаанд шилжүүлэхгүй нь тодорхой болсон;

- 14.5.2. Захиалагч ажлын хамрах хүрээг өөрчилсөн нь энэхүү гэрээнд заасан ажлын хөлсийг нэмэгдүүлэх нөхцөл байдлыг бий болгосон бөгөөд захиалагч нэмэлт санхүүжилтийг гаргахаас үндэслэлгүйгээр татгалзсан;
- 14.5.3. Гэрээгээр хүлээсэн үүргээ 2 буюу түүнээс дээш удаа ноцтой зөрчсөн.
- 14.6. Гэрээг цуцалсан тохиолдолд ийнхүү цуцалснаас хойш ажлын 3 хоногийн дотор гэрээ цуцалсан өдрөөр тасалбар болгон Захиалагч гуравдагч ажил гүйцэтгэгчээр ажлыг гүйцэтгүүлэх эрхтэй. Хэрэв гүйцэтгэгчийн зохих ёсоор гүйцэтгээгүй ажлыг гуравдагч ажил гүйцэтгэгч үргэлжлүүлэн гүйцэтгэх боломжтой тохиолдолд тухайн ажилд ногдох гүйцэтгэгчийн зардлыг захиалагч төлөх тохиолдолд гуравдагч ажил гүйцэтгэгчтэй зөвшилцсөнийг үндэслэн тооцно.
- 14.7. Гэрээнд заасны дагуу аль нэг Талын санаачилгаар Гэрээг цуцалсан бол буруутай Тал ийнхүү цуцалсантай холбоотой зардал болон нөгөө Талд учирсан хохирлыг нөхөн төлнө.

15. Хариуцлага

- 15.1. Гүйцэтгэгч нь ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй бол ийнхүү хугацаа хэтрүүлсэн хоног тутам гүйцэтгээгүй үүргийн гүйцэтгэлийн үнийн дүнгийн 0.3 хувьтай тэнцэх хэмжээний алданги төлнө.
- 15.2. Гэрээг захиалагчийн санаачлагаар цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч гэрээний нийт үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх хэмжээний торгууль хүлээх бөгөөд захиалагчид учирсан хохирлыг бүрэн хариуцна.
- 15.3. Захиалагч нь энэ гэрээнд заасан үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй бол ийнхүү хугацаа хэтрүүлсэн хоног тутам гүйцэтгээгүй үүргийн гүйцэтгэлийн үнийн дүнгийн 0,1 хувьтай тэнцэх хэмжээний алданги хүлээнэ.
- 15.4. Аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн, гэрээнд заасны дагуу нэг талын санаачилгаар гэрээг цуцалсан бол буруутай тал нөгөө талд учруулсан аливаа хохирол болон зардлыг нөхөн төлнө.
- 15.5. Хэрэв аль нэг тал нь үүргээ биелүүлээгүй тохиолдолд нөгөө тал нь шаардах эрхээ хэрэгжүүлээгүй бол энэ нь эрхээсээ татгалзсан гэж тооцохгүй бөгөөд эрхээ хожим хэрэгжүүлэх, шаардлагатай арга хэмжээ авахад саад болохгүй.
- 15.6. Аль нэг тал Гэрээгээр хүлээсэн үүргээ давагдашгүй хүчин зүйлийн улмаас зохих ёсоор биелүүлээгүй болох нь нотлогдвол үүрэг давагдашгүй хүчин зүйлийг арилах хүртэл хугацаагаар хойшлогдоно. Захиалагч төрийн эрх бүхий байгууллагаас хамааралтайгаар гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэхэд саад учирсан тохиолдолд Захиалагчийн үүрэг тухайн нөхцөлийг арилах хүртэл хугацаагаар хойшилно.


16. Маргаан шийдвэрлэх

- 16.1. Талууд харилцан хүндэтгэлтэй, бизнесийн ёс зүйг чанд сахиж, гэрээтэй холбоотой аливаа маргаан гарахаас урьдчилан сэргийлж ажиллана.
- 16.2. Энэхүү гэрээг тайлбарлах болон түүний заалтуудыг хэрэгжүүлэхтэй холбогдож гарсан аливаа маргааныг талууд харилцан тохиролцож шийдвэрлэхийг эрхэмлэнэ.
- 16.3. Талууд харилцан тохиролцоонд хүрэх боломжгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

17. ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Захиалагчийг төлөөлж:

“Монголын төмөр зам” ТӨХК
Гүйцэтгэх захирал




Б.НЭНГЭЛ

Инженер технологийн хэлтсийн дарга

Гүйцэтгэгч тал:


“Эрчим хүчний эдийн засгийн
хүрээлэн” ТӨҮГ-ын Захирал



М.ТҮМЭНЖАРГАЛ


Төсөл хөтөлбөрийн ахлах инженер


 Д.Нямлхагва
Цахилгааны инженер


 М.Цог-Эрдэнэ
Ерөнхий нягтлан бодогч


 Д.Даваадорж
Хуулийн мэргэжилтэн

М.Баянзул

 Ш.Энхбаатар
Ерөнхий нягтлан бодогч

 Л.Балган
Хууль, эрх зүйн мэргэжилтэн

 Ш.Сарантуяа



БАТЛАВ. АЖЛЫН ХЭСГИЙН ДАРГА БӨГӨӨД ЭРЧИМ ХҮЧНИЙ
ЯАМНЫ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН
ДАРГА Б.НАСАНТОГТОХ



ТАВАНТОЛГОЙ-ЗҮҮНБАЯН ЧИГЛЭЛИЙН ТӨМӨР ЗАМЫН
ЦАХИЛГААН ХАНГАМЖИЙН
ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

Олгосон огноо.

2019.05.08

№

32/2019/87

Улаанбаатар хот

Энэхүү техникийн нөхцөл нь 2020 оны 05 дүгээр сарын 02-ны өдрийг хүртэл / 1 жилийн хугацаанд/ хүчинтэй.

- 1. Техникийн нөхцөл хүссэн хуулийн этгээдийн нэр, хаяг** "МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ" ТӨХК
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 13-р хороолол, /14230/, Нарны зам-62, Юнион блюдинг, А блок, 7 давхар
- 2. Техникийн нөхцөл хүссэн газрын байршил** Өмнөговь аймаг, Цогтцэций сум,
Дорноговь аймаг, Мандах, Зүүнбаян сум
- 3. Ажил үйлчилгээний зориулалт** Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын цахилгаан хангамж
- 4. Техникийн нөхцөл олгох, сунгах үндэслэл** Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 135 дугаар тогтоол, "Монголын төмөр зам" ХХК-ийн 2019 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 01/357 тоот албан бичиг, мөн тус компанийн www.new.tog.mn цахим системийн 19-99-000284 дугаартай хүсэлт, "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн www.new.tog.mn цахим системийн 19-99-000224 дугаартай хүсэлт, "ЦДҮС" ТӨХК-ийн 2019 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 02/752 тоот албан бичиг, Эрчим хүчний яамны цахилгааны техникийн нөхцөл олгох ажлын хэсгийн 2019 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн хурлын шийдвэрийн тэмдэглэл
- 5. Олгосон чадал** 2030 кВА
- 6. Тоолуур** 6.1 RS 485 интерфэйсийн шаардлага хангасан, "IEC61107", "IEC62056" холболтын протоколтой, Монгол улсын Стандарт, Хэмжилзүйн Газраар баталгаажиж, ашиглахыг зөвшөөрсөн, санах ой бүхий 0.2 нарийвчлалтай бүрэн электрон тоолуур тавих

Зааврын 9 дүгээр хавсралт
 БҮРТГЭЛ-ХЯНАЛТЫН КАРТ

1 2 3 4 5 6 7 8 9 10 11 12 13 14 15 16 17 18 19 20 21 22 23 24 25 26 27 28 29 30 31																														
Баримт бичгийн нэр төрөл																														
Бүртгэсэн										Хаанаас, хэнээс буюу хаана хэнээс										Баримт бичгийн										
Он сар өдөр					Бүртгэлийн дугаар					Эрчим хүчний яам										Дугаар			Он сар өдөр			Хуудасны тоо				
2019 05 15					459															32/2019/ 187			2019 05.02			5				
Баримт бичгийн гарчиг /говч утга/ <i>Нэгжлэгдэн хэргийн ажил ТХЯ-ийн мэдээлэл</i>																														
Удирдлагын заалт /хэнд шилжүүлсэн/ <i>Засаг даргаар</i>																														
Баримт бичгийн шийдвэрлэх хугацаа <i>Нэгдүгээр арга хэмжээний өдөр өмнөд</i>																														

[Signature] 5/15. 2019

7. Гүйдлийн трансформатор

7.1 Хэрэглэгчийн ачаалалд тохирсон коэффициент бүхий Монгол Улсын стандартын шаардлага, реле хамгаалалт, хэмжүүр хэмжих хэрэгсэлд тавигдах шаардлагуудыг бүрэн хангасан, 0.2 нарийвчлалтай гүйдлийн трансформатор суурилуулах,

8. Холбогдох цэг

8.1 220/110/35 кВ-ын "Тавантолгой" дэд станцын 35 кВ-ын ил хуваарилах байгууламжийн I, II систем шинийг тус бүр 1 гаргалгаагаар /нийт 2 гаргалгаагаар/ өргөтгөн, 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам барьж, шинээр баригдах 35/0.4 кВ-ын дэд станцуудыг тэжээх.

8.2 220/22 кВ-ын "Цагаансуварга" дэд станцын 22 кВ-ын ил хуваарилах байгууламжийн I, II систем шинийг 1 гаргалгаагаар 22/35 кВ-ын өсгөх трансформатор /нийт 2 гаргалгаагаар/ өргөтгөн, 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам барьж, шинээр баригдах 35/0.4 кВ-ын дэд станцуудыг тэжээх.

8.3 35/6 кВ-ын "Зүүнбаян" дэд станцын 35 кВ-ын ил хуваарилах байгууламжийн I, II систем шинийг 1 гаргалгаагаар /нийт 2 гаргалгаагаар/ өргөтгөн, 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам барьж, шинээр баригдах 35/0.4 кВ-ын дэд станцуудыг тэжээх.

9. Тусгай заалтууд

9.1 220/110/35 кВ-ын "Тавантолгой", "Оюутолгой" дэд станцууд, 35/6 кВ-ын "Зүүнбаян" дэд станцын өргөтгөл:

9.1.1 Дэд станцуудын 35 кВ-ын ил хуваарилах байгууламжуудыг гаргалгааны 2 ячейкаар өргөтгөх.

9.1.2 35 кВ-ын гаргалгааны ячейк нь олон улсын IEC стандартын шаардлага хангасан гүйдлийн трансформатор, алсын удирлагатай вакуум таслуур, газардуулгын хутга бүхий хуурай салгуур, цэнэг шавхагч, реле хамгаалалт автоматик, хянах хэмжих хэрэгслүүдээр тоноглох.

9.1.3 Өргөтгөлийн ажилтай холбогдуулан, 35 кВ-ын ил хуваарилах байгууламжийн шин, дамжуулагч утас, изоляторууд болон бусад цахилгаан тоноглолуудыг зураг төсөл боловсруулах шатанд тооцоогоор сонгож, ашиглагч байгууллага "ЦДҮС" ТӨХК-тай зөвшилцөх.

9.1.4 Ачаалал нэмэгдэж байгаатай холбогдуулан, 35 кВ-ын ил хуваарилах байгууламжийн систем шинийн үндсэн болон бэлтгэл хамгаалалтуудыг тооцоо хийж, ашиглагч байгууллага "ЦДҮС" ТӨХК-тай зөвшилцөн сонгох, шаардлагатай тохиолдолд өргөтгөн шинэчлэх.

9.1.5 35 кВ-ын ил хуваарилах байгууламжийг өргөтгөж байгаатай холбогдуулан, зураг төсөл боловсруулах шатанд дэд станцын аянгын хамгаалалт, газардуулгын байгууламжийн тооцоо, хэмжилтийг хийж, тогтоосон дүрэм журмын шаардлагад хүргэх.

9.2 Тавантолгой дэд станцаас Зүүнбаян дэд станц хүртэл 35 кВ-ын 2 хэлхээ цахилгаан дамжуулах агаарын шугам барих.

9.3 Тавантолгой, Цагаансуварга, Зүүнбаян дэд станцын өргөтгөл хийгдсэн 35 кВ-ын гаргалгаанаас 2 хэлхээ цахилгаан дамжуулах агаарын шугам барьж, шинээр баригдах цахилгаан дамжуулах агаарын шугамыг хэсэгчлэн тэжээх.

9.4 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам нь аваарийн дизель станц болон 3 дэд станцаас хүчдэл орж ирэх боломжтой тул синхрон бус залгалтаас сэргийлсэн хоригуудыг заавал оруулсан байх,

9.5 Шинээр баригдах 35 кВ-ын 2 хэлхээ цахилгаан дамжуулах шугам:

9.5.1 Шинээр баригдах 35 кВ-ын 2 хэлхээ цахилгаан дамжуулах агаарын шугам нь MNS 6522:2015 стандартын шаардлагуудыг хангасан байх,

9.5.2 Шинээр баригдах цахилгаан дамжуулах агаарын шугамын дамжуулагчийн хөндлөн огтлолыг хэрэглээ ачаалалтай уялдуулан, тооцоогоор сонгох. Мөн утасны механик ачаалалд тохирсон үндсэн хийцүүд, хөндийрүүлэгч элементүүдийг зураг төслөөр сонгох

9.5.3 Цахилгаан дамжуулах агаарын шугамын үндсэн хийц болох анкер болон завсрын тулгуур нь төмөр болон төмөр бетон байх.

9.5.4 Цахилгаан дамжуулах агаарын шугамын үндсэн хийцүүд, дамжуулагч утас, хөндийрүүлэгч элементүүд, утас угсралтын тоног төхөөрөмжүүд нь Монгол улсын стандартын шаардлага хангасан байх, тухай газрын байгаль цаг уур, газарзүйн онцлогийг харгалзан зураг төслөөр сонгох,

9.5.5 Цахилгаан дамжуулах агаарын шугамын трассыг зураг төслийн шатанд "Монголын төмөр зам" ТӨХК, "БНӨБЦТС" ТӨХК, ӨБЦТС ТӨХК-уудтай зөвшилцөн сонгох.

9.6 Шинээр баригдсан цахилгаан дамжуулах агаарын шугамнаас салбарлуулан, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын өртөө зөрлөгүүдийн цахилгаан хангамжинд 35/0.4 кВ-ын дэд станц барьж цахилгаан эрчим хүчээр хангах.

9.7 Салбарлалтын анкер тулгуурын дараагийн тулгуур дээр анкер тулгууруудад хуурай салгуур бүхий реколоузерын пункт суурилуулах.

9.8 220/110/35 кВ-ын Тавантолгой дэд станцаас гарсан 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамнаас Тавантолгой өртөө, 60-р км-ийн зөрлөг-1, 129-р км-ийн зөрлөг-2, 189-р км-ийн зөрлөг-3 дэд станцуудыг тэжээх.

9.9 220/22 кВ-ын Цагаансуварга дэд станцаас гарсан 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамнаас Цагаансуваргын зөрлөг-4, 273-р км-ийн зөрлөг-5 дэд станцуудыг тэжээх.

9.10 35/6 кВ-ын Зүүнбаян дэд станцаас гарсан 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамнаас 340-р км-ийн зөрлөг-6, Зүүнбаян өртөөний дэд станцуудыг тэжээх.

9.11 35/0.4 кВ-ын дэд станцуудын байршлыг зураг төслийн шатанд "Монголын төмөр зам" ТӨХК-тай зөвшилцөх.

9.12 Шинээр баригдах 35/0.4 кВ-ын дэд станц нь MNS 6521:2015 стандартын шаардлага хангасан байх,

9.13 Дэд станцын оруулгыг олон улсын IEC стандартын шаардлага хангасан гүйдлийн трансформатор, алсын удирлагатай вакуум таслуур, газардуулгын хутга бүхий хуурай салгуур, цэнэг шавхагч, реле хамгаалалт автоматик, хянах хэмжих хэрэгслүүдээр тоноглох

9.14 Дэд станц нь 35/0.4 кВ-ын трансформаторын хүчин чадлыг зураг төслийн шатанд тооцоогоор сонгох, Трансформатор нь олон улсын IEC 600076-10 стандартын шаардлагыг хангасан байх,

9.15 "Цахилгаан эрчим хүч хэрэглэгчийн цахилгаан хангамжийн зэрэглэл тогтоох журам"-д заасны дагуу I зэрэглэлийн хэрэглэгч тул болзошгүй аваар саатал, тасралтын үед өөрийн хэрэгцээг хангах ажиллах аваарийн нөөц эх үүсвэр /дизель станц/-г суурилуулж, туршилт тохируулгыг бэлэн байдлыг хангах.

9.16 Шинэ баригдах дэд станцуудын оруулга, цахилгаан дамжуулах агаарын шугамын дунд гэмтэлтэй хэсгийг тусгаарлах хуурай салгуур бүхий реколоузерын пункт суурилуулах. Зураг төслийн шатанд олон улсын стандартын шаардлага хангасан орчин үеийн микропроцессорын хамгаалалтыг холбогдох богино залгааны тооцоонуудыг хийж сонгох,

9.17 35 кВ-ын дэд станц нь ажлын байрны шаардлага хангасан удирдлагын байртай байх,

9.18 220/110/35 кВ-ын Тавантолгой, 220/22 кВ-ын Цагаансуварга, 35/6 кВ-ын Зүүнбаян дэд станцуудтай холбогдох шуурхай ажиллагааны холбоог ашиглагч байгууллага ЦДҮС ТӨХК, БНЗӨБЦТС ТӨХК, Монголын төмөр зам ТӨХК-уудтай зөвшилцөх суурилуулах.

9.19 Шинээр суурилуулж буй тоноглолууд нь өмнө ашиглагдаж байгаагүй шинэ байх, $\pm 10\%$ -ийн хүчдлийн хэлбэлзэлд хэвийн ажиллах,

9.20 Дэд станцуудад галын хор, щит, самбар, пунктыг галын аюулгүйн дүрэмд заагдсаны дагуу байрлуулж, галын аюулгүй байдлыг хангах,

9.21 Техникийн нөхцөлийн дагуу шинээр суурилуулах тоноглолууд, кабель шугам, трансформаторууд нь сүүлийн үеийн байгаль орчинд ээлтэй, дэвшилтэд техник технологи бүхий байх,

9.22 Шугам, дэд станцын гүйцэтгэлийн зургийг гаргаж, ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөх,

10. Дор дурдсан техникийн даалгавар, хууль дүрмийг мөрдөх:

10.1 Дэд станц, цахилгаан дамжуулах шугамын байршлын зургийг эрх бүхий байгууллагаар хийлгэж, тухайн орон нутгийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газраар батлуулан, мэдээллийн санд оруулсан байх,

10.2 Цахилгаан шугам сүлжээнд холбогдох явцад трассын дагуу дайрч гарах зам талбай, бут сөөгийг сэргээх зардлыг төсөвт тусгах,

10.3 Шугам, дэд станцын зураг төсөл боловсруулах, угсралт, туршилт, тохируулгын ажлыг "Цахилгаан байгууламжийн угсралтын дүрэм" (2003 он), Эрчим хүчний тоног төхөөрөмжийн техник ашиглалтын дүрэм, Цахилгаан байгууламжийн ашиглалтын үед мөрдөх аюулгүй ажиллагааны дүрмийн дагуу эрчим хүчний барилга байгууламжийн зураг төсөл ба угсралтын ажлыг гүйцэтгэх "Тусгай зөвшөөрөл" бүхий мэргэжлийн компаниар гүйцэтгүүлэх,

10.4 "Эрчим хүчний тухай" хуулийн 29.1.9 "Хангагч нь хэрэглэгчийн өмчлөлийн шугам, дэд станцаас нутаг дэвсгэрийн хэтийн төлөвийн үндсэн дээр өөр бусад хэрэглэгчийг нэмж болох эрхтэй" гэж заасны дагуу өөрийн тоноглолоос хангагч байгууллагын зөвшөөрлөөр шинээр хэрэглэгч нэмж холбуулах үүрэгтэй.

10.5 "Эрчим хүчний тухай" хуулийн 30.1.8 "Өөрийн эзэмшлийн шугам, сүлжээ, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн, аюулгүй байдал, засвар үйлчилгээ, баталгаажуулалтыг бүрэн хариуцах" гэж заасны дагуу өөрийн ашиглалт үйлчилгээний зааг доторхи цахилгаан тоног төхөөрөмжиндөө байнгын үзлэг шалгалт хийх, хэвийн бус ажиллагаатай үед өөрсдийн хөрөнгөөр засвар үйлчилгээг хийлгэх,

10.6 Хэрэглэгч нь өөрийн эзэмшлийн цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааг хариуцсан ажилтныг томилох бөгөөд шугам сүлжээний хамгаалалтын зурвас дотор гэр, орон сууц, барилга байгууламж барихыг хориглоно.

10.7 Зураг төсөл боловсруулах шатанд холболт хийх цэг, шуурхай ажиллагааны нэрийг "ЦДҮС", "ӨБЦТС" ТӨХК, БНЗӨБЦТС ТӨХК, Монголын төмөр зам ТӨХК-үүдтэй зөвшилцөх,

10.8 Реле хамгаалалт автомастикийн сонгохдоо холбогдох тооцоог хийж, ДҮТ ХХК-тай зөвшилцөх, тавилын тооцоог тус компаниар хийлгэх.

10.9 Зургийн даалгаврыг Эрчим хүчний яамны Бодлого төлөвлөлтийн газраас авах

11. Эрчим хүчний сайдын 2013 оны 01 дүгээр сарын 04-ны өдрийн 03 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Цахилгаан эрчим хүчээр хангах техникийн нөхцөл олгох журам"-ын 5 дахь хэсэгт заасан доорх заалтуудыг мөрдлөг болгоно.

5.2 Техникийн нөхцөлийг дараах үндэслэлээр хүчингүй болгоно. Үүнд:

5.2.1 Техникийн нөхцөл авахын тулд техникийн хэрэглээний өгөгдлүүдээ зориуд буруу тодорхойлсон,

5.2.2 Холболт хийх цэгийн хүчин чадлаас хэтрүүлэн техникийн нөхцөл олгосон,

5.2.3 Техникийн нөхцөлийн хүчинтэй байх хугацаанд цахилгааны сүлжээнд холбогдоогүй тохиолдолд,

5.2.4 Хугацаа дууссан техникийн нөхцөлөөр зураг төсөл боловсруулах, барилга байгууламж барихыг хориглоно.

5.2.5 Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаа дуусахаас 1 сарын өмнө сунгуулах хүсэлтийг ажлын хэсэгт гаргана. Хугацаа дууссан техникийн нөхцөлийг хүчингүй тооцно.

АЖЛЫН ХЭСГИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ОРЛОГЧ ДАРГА:

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ
ГАЗРЫН ЦАХИЛГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА Д.БАТЗОРИГ

ГИШҮҮД:

"ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ" ТӨХК-ИЙН ТЭРГҮҮН ДЭД
ЗАХИРАЛ БӨГӨӨД ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР Б.ДАШДАВАА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН
ЦАХИЛГААНЫ ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН М.ГАНСҮХ

ХҮСЭЛТ ГАРГАСАН ХУУЛИЙН ЭТГЭЭД БУЮУ ХЭРЭГЛЭГЧ:

Хүлээн авч, техникийн нөхцөлийн хүчингүй болгох заалттай танилцсан эсэх



Тийм



Үгүй

Нэр: М. Уор-Энэ

Гарын үсэг: [Харын үсэг]

Регистрийн дугаар:

УЕ 791009711

Холбоо барих:

8020 4422

Он сар өдөр

2019-05-15

БАТЛАВ:
ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ БОДЛОГО,
ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН ДАРГА



Т.ЭНХТАЙВАН

**ТАВАНТОЛГОЙ-ЗҮҮНБАЯН ЧИГЛЭЛИЙН ТӨМӨР ЗАМЫН ЦАХИЛГААН
ХАНГАМЖИЙН АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР**

2019.05.13

Улаанбаатар хот

Дугаар: 2019/2-39

- | | |
|---|---|
| 1. Зураг төсөл
боловсруулах
үндэслэл | 1.1 "Монголын төмөр зам" ТӨХК-ийн 2019 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 01/443 тоот албан хүсэлт,
1.2 Эрчим хүчний яамны 2019 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 32/2019/87 тоот техникийн нөхцөл, |
| 2. Байршил | Өмнөговь аймаг, Өмнөговь аймаг, Цогтцэций сум, Дорноговь аймаг, Мандах, Зүүнбаян сум |
| 3. Объектийн
бүрэлдэхүүн, хүчин
чадал | 3.1 Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын цахилгаан хангамж, 2030 кВА
3.2 220/110/35 кВ-ын "Тавантолгой" дэд станцын 35 кВ-ын ил хуваарилах байгууламжийн I, II систем шинийг тус бүр 1 гаргалгаагаар /нийт 2 гаргалгаагаар/ өргөтгөн, 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам /ЦДАШ/ барьж, шинээр баригдах 35/0.4 кВ-ын дэд станцуудыг тэжээх,
3.3 220/22 кВ-ын "Цагаансуварга" дэд станцын 22 кВ-ын ил хуваарилах байгууламжийн I, II систем шинийг 1 гаргалгаагаар 22/35 кВ-ын өсгөх трансформатор /нийт 2 гаргалгаагаар/ өргөтгөн, 35 кВ-ын ЦДАШ барьж, шинээр баригдах 35/0.4 кВ-ын дэд станцуудыг тэжээх,
3.4 35/6 кВ-ын "Зүүнбаян" дэд станцын 35 кВ-ын ил хуваарилах байгууламжийн I, II систем шинийг 1 гаргалгаагаар /нийт 2 гаргалгаагаар/ өргөтгөн, 35 кВ-ын ЦДАШ барьж, шинээр баригдах 35/0.4 кВ-ын дэд станцуудыг тэжээх,
3.5 Дэд станцуудын 35 кВ-ын ил хуваарилах байгууламжуудыг гаргалгааны 2 ячейкаар өргөтгөх,
3.6 Шинээр суурилуулах ячейк нь олон улсын IEC стандартын шаардлага хангасан гүйдлийн трансформатор, алсын удирлагатай вакуум таслуур, газардуулгын хутга бүхий хуурай салгуур, цэнэг шавхагч, реле хамгаалалт автоматик, хянах хэмжих хэрэгслүүдээр тоноглох,
3.7 Ачаалал нэмэгдэж байгаатай холбогдуулан, 35 кВ-ын ил хуваарилах байгууламж /ИХБ/-ийн систем шинийн үндсэн болон бэлтгэл |

Зааврын 9 дүгээр хавсралт
 БҮРТГЭЛ-ХЯНАЛТЫН КАРТ

1			2			3			4			5			6			7			8			9			10			11			12			13			14			15			16			17			18			19			20			21			22			23			24			25			26			27			28			29			30			31		
Баримт бичгийн нэр төрөл																																																																																												
Бүртгэсэн										Хаанаас, хэнээс буюу хаана хэнд										Баримт бичгийн																																																																								
Он сар өдөр					Бүртгэлийн дугаар					Эрчим хүчний яам										Дугаар				Он сар өдөр				Хуудасны тоо																																																																
2019 05.15					458															2019/ 4-39				2019 05.13				4																																																																
Баримт бичгийн гарчиг /товч утга/ Цахилгаан хангамжийн өмчийн зурвас тосгон болон баруулах даатгал.																																																																																												
Удирдлагын заалт /хэнд шилжүүлсэн/ Табаруу газар																																																																																												
Баримт бичгийн шийдвэрлэх хугацаа Хийгээрх арга хэлтэж өвч амьсгал																																																																																												

[Handwritten signature]
 2019.

хамгаалалтуудыг тооцоо хийж, ашиглагч байгууллага “ЦДҮС” ТӨХК, “БНЗӨБЦТС” ТӨХК, “Монголын төмөр зам” ТӨХК-уудтай зөвшилцөх сонгох, шаардлагатай тохиолдолд өргөтгөн шинэчлэх,

- 3.8 Тавантолгой дэд станцаас Зүүнбаян дэд станц хүртэл 35 кВ-ын 2 хэлхээ ЦДАШ барих,
- 3.9 Тавантолгой, Цагаансуварга, Зүүнбаян дэд станцын өргөтгөл хийгдсэн 35 кВ-ын гаргалгаанаас 2 хэлхээ ЦДАШ барьж, шинээр баригдах ЦДАШ-ыг хэсэгчлэн тэжээх,
- 3.10 35 кВ-ын ЦДАШ нь аваарийн дизель станц болон 3 дэд станцаас хүчдэл орж ирэх боломжтой тул синхрон бус залгалтаас сэргийлсэн хоригуудыг заавал оруулсан байх,
- 3.11 Шинээр баригдах 35 кВ-ын хоёр хэлхээ ЦДАШ нь MNS 6522:2015 стандартын шаардлага хангасан байх, дамжуулагчийн хөндлөн огтлолыг ачаалалтай уялдуулан тооцоогоор сонгох,
- 3.12 ЦДАШ-ын трассыг зураг төслийн шатанд орон нутгийн болон ашиглагч “ЦДҮС” ТӨХК, “БНЗӨБЦТС” ТӨХК, “Монголын төмөр зам” ТӨХК-уудтай зөвшилцөн сонгох, трассыг бусад шугамын гаргалгаа, трасстай аль болох давхцуулахгүй байх,
- 3.13 ЦДАШ-ын тулгуур нь MNS:4232-2011 стандартын шаардлагыг хангасан байх, салбарлалтын анкер тулгууруудад хуурай салгуур бүхий реколоузерын пункт суурилуулах,
- 3.14 Шинээр баригдсан ЦДАШ-аас салбарлуулан, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын өртөө зөрлөгүүдийн цахилгаан хангамжинд 35/0.4 кВ-ын дэд станц барьж цахилгаан эрчим хүчээр хангах,
- 3.15 220/110/35 кВ-ын Тавантолгой дэд станцаас гарсан 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамнаас Тавантолгой өртөө, 60-р км-ийн зөрлөг-1, 129-р км-ийн зөрлөг-2, 189-р км-ийн зөрлөг-3 дэд станцуудыг тэжээх,
- 3.16 220/22 кВ-ын Цагаансуварга дэд станцаас гарсан 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамнаас Цагаансуваргын зөрлөг-4, 273-р км-ийн зөрлөг-5 дэд станцуудыг тэжээх,
- 3.17 35/6 кВ-ын Зүүнбаян дэд станцаас гарсан 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамнаас 340-р км-ийн зөрлөг-6, Зүүнбаян өртөөний дэд станцуудыг тэжээх,
- 3.18 Шинээр баригдах 35/0.4 кВ-ын дэд станц нь MNS 6521:2015 стандартын шаардлага хангасан байх, дэд станцын тоо, хүчин чадлыг хэрэглээтэй нь уялдуулан тооцоогоор сонгох, дэд станцын байршлыг зураг төслийн шатанд “Монголын төмөр зам” ТӨХК-тай зөвшилцөх,

